



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 4/04

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Төрийн албаны тухай хуулийн 54.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 37, 38 дугаар тогтоол, “Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүтцийн нэгжийн 2021 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үүрэг бүхий үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Мөнхсайхан

Тэргүүн дэд дарга, хурандаа,

Гишүүд:

Э.Эрдэнэбаатар

Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа,

Б.Баттулга

Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, хурандаа,

Г.Нэргүй

Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа,

Л.Тэгшбаяр

Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, дэд хурандаа,

Д.Урантулга

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, хурандаа,

Ж.Төмөрмандах

Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга, хошууч,

Нарийн бичиг:

Ч.Батболд

Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ эрсдэлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, ахмад,

2. Нийслэлийн Онцгой байдлын газрын дотоод нэгжийн алба хаагчид, бүтцийн нэгжийн төлөвлөгөөний хянан баталгаажуулсан тайланг улирал бүр хүлээн авч, дараа сарын 10-ны өдрийн дотор дүгнэн баталгаажуулж ажиллахыг үнэлгээний багийн ахлагч хурандаа Д.Мөнхсайханд үүрэг болгосугай.

ДАРГА,
ХУРАНДАА



А.ДАШНЯМ

000145